



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 4/91

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Багийн Засаг дарга, Цагдаа, Байгаль хамгаалагч нарын албан хэрэгцээнд мотоцикл” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Өлзийжаргал (УБХ-ийн дарга)
Гишүүд: Ц.Бямбацогт (Иргэний төлөөлөл)
Г.Жавзмаа (АЗДТГ-ын мэргэжилтэн)
Х.Анхбаяр (БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: С.Ууганбаяр (ОНӨГ-ын дарга)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Өлзийжаргал)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (С.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190261